



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/224

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 14, 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалан сумын НАҮТөв төрийн өмчит үйлдвэрийн газрын усан сан 2022 оны 19-ний өдрөөс 20-нд шилжих шөнө нурж, гамшиг осол тохиолдсонтой холбогдуулан гарсан зардалд 13,093,000 (Арван гурван сая ерэн гурван) төгрөг, Рэнчинлхүмбэ сумын шар усны үерээс үүдэлтэй зам засварын ажлын шатахууны зардалд 5,000,000 (Таван сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх зардлын нийт 18,093,000 (Арван найман сая ерэн гурван) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй. 3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН